2013/06

Увс аймгийн нийгэм эдийн засгийн байдлын танилцуулга

- *Ажиллагсдын тоо, дундаж цалингийн түүвэр судалгааны дүн 2013-1-р улирал*
- *Ажиллах хүчний судалгааны дүн 2013 оны 1-р улирал*
- *ӨНЭЗС-ын дүн,2013 оны 1-р улирал*

Статистикийн хэлтэс

Улаангом хот

АГУУЛГА

Аргачлалын тайлбар 3

I. Нийгмийн үзүүлэлт

1.1 Хүн ам 4
1.2 Нийгмийн даатгал, халамж,нөхөн олговор 4
1.3 Хөдөлмөр 6
1.4 Эрүүл мэнд 8
1.5 Соёл 13
1.6 Гэмт хэрэг,шүүх 15

II. Макро эдийн засгийн үзүүлэлт

2.1 Хэрэглээний бараа үйлчилгээний үнэ 16
2.2 Мөнгө зээл 22
2.3 Орон нутгийн төсвийн орлого 23
2.4 Орон нутгийн төсвийн зарлага 25
2.5 Орон нутгийн төсвийн өглөг,авлага 25
2.6 Гадаад худалдаа 26

III. Эдийн засгийн салбарын үзүүлэлт

3.1 Аж үйлдвэр 27
3.2 Барилга 32
3.3 Хөдөө аж ахуй
3.3.1 Төллөлт төл бойжилт 33
3.3.2 Том малын зүй бусын хорогдол 34
3.3.3 Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний дундаж үнэ 35
3.3.4 Үр тариа,төмс, хүнсний ногоо тариалалт 36

IV Бусад салбарын үзүүлэлт

4.1 Тээвэр холбоо 36
5.1 Цаг уурын байдал 37
6.1 Аюулт үзэгдэл,ослын мэдээ 37

Хүснэгтэн мэдээллүүд

Аймгийн үндсэн үзүүлэлт 38-39
Нийгмийн даатгал, нөхөн олговор 40-42
Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 43
Ажлын шинэ байрны мэдээ 43-48
Эрүүл мэнд 49-51
Соёлын үзүүлэлтүүд 52
Гэмт хэрэг , шүүх 52-54
Хэрэглээний үнийн индекс 55-56
Зээл хадгаламж 56-60
Төсвийн орлого, зарлага, өглөг 61-64
Экспорт, импорт 65
Аж үйлдвэр 66-68
Барилга 69
ХАА 70-77
Тээвэр холбоо 78
Цаг уур 79
Дундаж цалингийн түүвэр судалгааны 2013 оны 1-р улирлын дүн 80-82
Хэрэглэгчдэд зориулсан лавлагаа 83
Ажиллах хүчний судалгааны 2013 оны 1-р улирлын танилцуулга 84-88
Өрхийн судалгааны 2013 оны 1-р улирлын танилцуулга 89-91

Аргачлалын тайлбар:

ОРОН НУТГИЙН ТӨСӨВ

Төсвийн орлого зарлагын тооцоог Олон улсын Валютын сангийн стандарт ангиллаар 1995 оны 10-р сараас эхлэн гаргаж байна. Төсвийн орлогын мэдээг аймгийн Татварын хэлтэс, төсвийн зарлага, санхүүжилтийн мэдээг СТС-ийн хэлтсээс гаргадаг.

Төсвийн орлогын мэдээг хэрэглэгчдэд илүү тодорхой болгох зорилгоор аймгийн нийт төсвийн орлого, үүнээс улсын төвлөрсөн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөний биелэлт, орон нутгийн төсвийн орлого, үүнээс улсын төсөвт /аймгийн/ төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөний биелэлт гэж салгаж харууллаа. Төсвийн зарлагыг эдийн засгийн салбарын ангиллаар гаргаж, улсын төсвийн байгууллагууд, орон нутгийн төсвийн байгууллагууд гэж тус тусдаа гарсныг нэгтгэж оруулаа.

ҮНЭ

Аймгийн төвийн хүнсний зах дээр борлогдож байгаа хөдөө аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдхүүн, ноос, ноолуур, арьс шир зэрэг зарим бүтээгдхүүний зах зээлийн дундаж үнийг харуулав.

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь өрх орлогоороо өөрсдийн хэрэгцээнд худалдан авсан,үйлчлүүлсэн хамгийн чухал, эн тэргүүний нийтлэг хэрэгцээтэй бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг тэдгээрийн хэрэглээний зардалд эзлэх хувиар жигнэсэн дундаж юм.

2012 оноос эхлэн хэрэглээний сагсны нэр төрлийг шинэчилж 213 нэр төрөл болгож 2010 оны 12-р сарын үнээр суурилан ХҮИ-ийг тооцож байна.

АЖ ҮЙЛДВЭР

Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар нь ангилахдаа НҮБ-ын эдийн засгийн үйл ажиллагааны Олон улсын стандарт ангиллыг мөрдөж байна.

Аж үйлдвэрийн борлуулсан бүтээгдхүүн нь аж ахуйн нэгж, байгууллагын тайлангийн хугацаанд буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Аж үйлдвэрийн нийт бүтээгдхүүний өсөлтийг гол нэр төрлийн бүтээгдхүүнийг 2005 оны зэрэгцүүлэх үнээр үнэлж тодорхойлсон болно.

Гол нэр төрлийн бүтээгдхүүний үйлдвэрлэл нь тухайн бүтээгдхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээг харуулна.

ХӨДӨЛМӨР

Ажилгүйчүүдийн тоонд олон улсын стандарт ангиллын дагуу Монгол улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, нөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувираа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй эрж, хайж байгаа хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгүүлсэн хүмүүс орно.

ЭРҮҮЛ МЭНД

Нялхсын нас баралт (1 хүртэл насны 1000 хүүхдэд ногдох) –ыг тухайн үед 1 хүртэлх насны нас барсан хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.

ГЭМТ ХЭРЭГ

18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоог гаргахдаа нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоог жилийн дундаж 18 ба түүнээс дээш насны хүн амд харьцуулан тооцно

ХАА-н САЛБАР

Аймгийн ИТХ-ын 2002 оны ээлжит 8-р хуралдаанаар баталсан бүсүүд:
Баруун бүс : Завхан, Наранбулаг, Өлгий, Өмнөговь, Тариалан, Ховд
Хойт бүс : Бөхмөрөн, Давст, Сагил, Түргэн
Зүүн бүс: Зүүнговь, Малчин, Тэс, Хяргас
Өмнөт бүс:Баруунтуруун, Зүүнхангай, Өндөрхангай, Цагаанхайрхан
Төвийн бүс : Улаангом хот

ТЭМДЭГЛЭГЭЭНИЙ ТАЙЛБАР :

1. Саруудыг ром тоогоор тэмдэглэв. (I, II, III , IV, V..... г.м)
I-XII жилийн эхний тухайн сарыг оруулсан өсөн нэмэгдэх дүнг харуулав.
2. Дараахь тэмдэглэлүүдийг ашиглав :
... мэдээлэл байхгүй
0.0 маш бага тоо
- гүйцэтгэл байхгүй
Д - дахин
3. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрөх тохиолдол байж болно.

I. НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

1.1 ХҮН АМ

Энэ оны эхний 6 сарын байдлаар 1004 эхээс 1007 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс төрсөн хүүхдийн тоо 4 – ээр буюу 0.4 хувиар буурсан байна.
Гэрийн төрөлт 11 гарсан нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 5 төрөлтөөр илүү байна.



Хүн амын төрөлтийн тоо өмнөх 4 жилийн дунджаас 5.3 хувиар буурсан байна.
Хүн амын нас баралт 208 гарч өнгөрсөн оны мөн үеэс 12.2 хувиар буурсан бөгөөд 1000 хүнд 2.8 ноогдох болсон нь ноднингийн мөн үеэс 0.4 промилээр бага байна.



Эхний хагас жилд 1000 хүн амд ноогдох цэвэр өсөлт 10.8 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 0.4 промилээр, өмнөх 4 жилийн дунджаас 0.2 промилээр тус тус өссөн байна.

1.2 НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ, НӨХӨН ОЛГОВОР

НДС-д шимтгэлээр 5113.5 сая төгрөг оруулахаас 5986.2 сая төгрөг оруулж төлөвлөгөөг 117.1 хувиар биелүүлсэн байна. 2012 оны эхний 6 сартай харьцуулахад НДШ-ийн орлого 1509.5 сая төгрөгөөр буюу 33.7 хувиар өссөн байна.

Сангуудаар авч үзвэл ЭМ –ийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө 1.0 хувиар, тэтгэмжийн даатгалын сангийн орлого 5.4 хувиар, тэтгэврийн даатгалын сангийн орлого 25.8 хувиар, ҮОМШӨ даатгалын орлого 5.7 хувиар, ажилгүйдлийн даатгалын сангийн орлого 15.6 хувиар тус тус давж биелэгдсэн байна.

НДС-ийн шимтгэлийн орлогын төлөвлөгөөг бүх сумдууд 5.2 – 63.5 хувиар давуулан биелүүлсэн байна.

Нийгмийн даатгалын сангийн орлого, төрлөөр, мян.төг



Сангуудаар авч үзвэл өнгөрсөн оны мөн үеэс тэтгэврийн даатгалын орлого 41.0 хувиар, ЭМД-н сангийн орлого 21.9 хувиар, тэтгэмжийн даатгалын сангийн орлого 84.5 хувиар, ҮОМШӨ-н сангийн орлого 19.7 хувиар тус тус өссөн бөгөөд ажилгүйдлийн даатгалын сангийн орлого 46.0 хувиар буурсан байна.

Нийгмийн даатгалын сангийн зарлага, төрлөөр, сая.төг



9.7 тэрбум төгрөг тэтгэвэрт, 1385.2 сая төгрөг ЭМД-ын санхүүжилтэнд зориулан зарцуулж тэтгэвэр тэтгэмжийг бүрэн олгосон байна.

НДС 125.7 сая төгрөгийн авлагтай байгаа бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс 76.8 сая төгрөгөөр буюу 2.6 дахин өссөн байна.

Нийгмийн даатгалын сангуудын зарцуулалт, бүтцээр, 2013 оны 6-р сар



Тэтгэмжийн даатгалын сангаас 486.2 сая төгрөг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас 55.2 сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 214.7 сая төгрөг, нийтдээ даатгалын сангуудаас 11.8 тэрбум төгрөг зарцуулсан бөгөөд өнгөрсөн оноос 2757.6 сая төгрөгөөр буюу 30.4 хувиар өссөн байна.

Нийгмийн халамжийн сангаас 2013 оны 6-р сард 25.8 мянган хүнд 4.1 тэрбум төгрөг зарцуулснаас улсын төсвөөс олгосон тэтгэмж, тусламжинд / алдар цолтой ахмадуудад, алдарт эхийн одонгийн / 1168.4 сая төгрөг, орон нутгийн халамжийн сангаас халамжийн тэтгэвэрт 1819 хүнд 1266.2 сая төгрөг, нөхцөлт мөнгөн тэтгэмжинд 1104 хүнд 404.8 сая төгрөг, амжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламж 294.1 сая, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх тусламжинд 292.3 сая төгрөг, жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эхчүүдэд үзүүлсэн хөнгөлөлт 435.4 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Энэ оны 6-р сард 748 өрхийн 4760 хүнд 48.0 сая төгрөг, эхний хагас жилд нийт 205.1 сая төгрөгийн хүнс тэжээлийн тусламж үзүүлсэн байна. Энэхүү тусламжаар 0-18 насны 1 хүүхдэд 5000 төгрөг, 1 том хүнд 10000 төгрөгийн тусламж өгч байна.

Асрамжийн газар нийт 14 хүн асруулж байгаа бөгөөд 6 эмэгтэй, 5 хүүхэд байна. Асрамжийн үйл ажиллагаанд нийт 142.9 сая төгрөгийг зарцуулсан байна.

1 хүнд 396.4 мянган төгрөгийн нөхөн олговор олгогдсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс нөхөн олговорын мөнгө 235.4 мянган төгрөгөөр буюу 37.3 хувиар буурсан байна.

1.3 ХӨДӨЛМӨР

Аймгийн хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгүүлсэн ажил идэвхитэй хайж байгаа ажилгүй хүний тоо 1069 болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 36.7 хувиар буюу 287 хүнээр өссөн байна. Аймгийн хэмжээнд 643 эмэгтэй ажил идэвхитэй эрж байгаа нь ажилгүйчүүдийн 60.1 хувийг эзэлж байна.

Оны эхний 6 сарын байдлаар бүртгүүлсэн, ажил идэвхитэй эрж байгаа ажилгүйчүүдийн тоо өмнөх 4 жилийн дунджаас 29.5 хувиар буюу 448 ажилгүйчүүдээр буурсан байна. Бүртгэлтэй ажилгүйчүүдийн 3.0 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд байна.

Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо, сүүлийн 5 жилээр



Бүртгэлтэй ажилгүйчүүдийг насны бүлгээр авч үзвэл 23.2 хувь нь 15-24 насны, 31.9 хувь нь 25-34 насны, 26.3 хувь нь 35-44 насны, 18.6 хувь нь 45-59 насны ажилгүйчүүд байна. Ажилгүйчүүдийн 22.6 хувь нь дээд, 19.9 хувь нь тусгай дунд болон мэргэжлийн анхан шатны 53.5 хувь нь бүрэн ба бүрэн бус дунд боловсролтой, 3.9 хувь нь бага болон боловсролгүй хүмүүс эзэлж байна.

16 дээш насны арван мянган хүнд 225 ажилгүйчүүд ноогдож байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 38.3 хувиар өссөн байна.

Хөдөлмөрийн хэлтсээс гаргасан эхний 6 сарын мэдээгээр 795 ажлын байр эдийн засгийн үйл ажиллагааны салбар, ажил, мэргэжлийн ангилал, байгууллагын өмчийн болон хариуцлагын хэлбэрээр зарлагдсан байна.

Ажлын байрны, захиалга, салбараар



Ажлын шинэ байрыг эдийн засгийн ангилалаар авч үзэхэд 13.1 хувийг ХАА, ойн аж ахуй, ан агнуур, 19.5 хувийг боловсруулах үйлдвэрлэл, 13.8 хувийг барилга, 4.7 хувийг бөөний болон жижиглэн худалдаа, 1.3 хувийг зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ, 1.5 хувийг мэдээлэл холбоо, 3.9 хувийг санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа, 2.8 хувийг удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа, 23.8 хувийг төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалалын салбар, 4.9 хувийг боловсролын салбар, 1.3 хувийг урлаг, үзвэр, тоглоом наадам, 9.6 хувийг үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбар эзэлж байна.

Ажлын байрны захиалга, ажил мэргэжлийн ангиллаар



Хөдөлмөрийн албаар дамжин шинэ болон сул чөлөөтэй байгаа ажлын байранд 557 хүн ажилд зуучлагдан орсон байна. Ажилд зуучлагдан орсон хүмүүсийн 45.8 хувь нь эмэгтэйчүүд байна.

Ажлын шинэ болон сул чөлөөтэй байранд ажилд орсон хүн, салбар, бүтцээр



2013 оны 1000 ажлын байр шинээр бий болгох зорилттойгоос 615 шинэ ажлын байр бий болж зорилтын биелэлт 61.5 хувьтай байна. Ажилд орсон хүмүүсийн 50.2 хувь нь эмэгтэйчүүд байна.

Ажлын шинэ байранд ажилд орсон хүмүүс, ажил мэргэжлийн ангилалаар

Шинэ ажлын байранд орсон хүмүүсийн 2.6 хувь нь менежер, 12.2 мэргэжилтэн, 0.8 техникч болон туслах ажилтан, 0.8 хувь нь контор, үйлчилгээний ажилтан, 5.4 хувь нь худалдаа, үйлчилгээний ажилтан, 22.4 ХАА, ой, загас агнуурын ажилтан, 51.8 хувь нь үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээний, 1.1 суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч, 2.9 хувь нь энгийн ажил мэргэжилд ажилд орсон байна.

1.4 ЭРҮҮЛ МЭНД

Аймгийн хэмжээнд оны эхний 6 сард нэг хүртэлхи насандаа 20 хүүхэд эндэж, өмнөх оны мөн үеийнхээс 3 хүүхдээр илүү байгаа бол 1 – 5 хүртэлхи насны хүүхдийн эндэгдэл 5 гарсан нь өмнөх оны мөн үеийн түвшинд байна. Жирэмслэлт болон төрөлтийн улмаас эхийн эндэгдэл гараагүй байна.



5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин / амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох / Цагаанхайрханд 250, Тариаланд 200, Зүүнговьд 125, Өлгий суманд 100, Бөхмөрөнд 100, Тэсд 80, Завханд 62.5, Хяргаст 58.8, Зүүнхангайд 50, Өндөрхангайд 47.6, Баруунтуруунд 38.5 байгаа нь аймгийн дунджаас 13.7 – 225.2 промилээр өндөр, Улаангом сум аймгийн дунджаас 12.3 промилээр бага, бусад сумдад гараагүй байна.



0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 20 гарч, 1000 амьд төрөлтөд ноогдох нялхсын эндэгдлийн түвшин 19.9 байгаа нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 3.1 промилээр өссөн байна. Өмнөх 4 жилийн дунджаас нялхсын эндэгдлийн түвшин 9.8, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 11.5 промилээр тус тус буурсан байна.

Нялхсын эндэгдлийн түвшин Цагаанхайрхан, Тариалан, Тэс, Завхан, Хяргас, Зүүнхангай, Өндөрхангай, Баруунтуруун сумдад аймгийн дунджаас 18.6 – 230.1 промилээр өндөр, Улаангом суманд аймгийн дунджаас 8.8 промилээр бага, бусад сумдад гараагүй байна.

Нийт нас баралтын 20.7 хувийг эмнэлэгийн нас баралт эзэлж өнгөрсөн оны мөн үеэс 12.2 хувиар буурсан байна. Осол гэмтлийн улмаас 24 хүн нас барж, өвчлөгчдийн тоо 475 байна. Осол гэмтлийн улмаас нас барагчдын тоо өмнөх 3 жилийн дунджаас 20 хувиар буурч, өвчлөгчдийн тоо 24.0 хувиар өссөн байна.

Хорт хавдраар өвчлөгчдийн тоо 57 болж, 63 хүн нас барсан байна.



Хорт хавдраар өвчлөгсдийн тоо өмнөх 3 жилийн дунджаас 8.6 хувиар, нас барагсдын тоо 3.1 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 288 болж өнгөрсөн оны мөн үеэс 17 хувиар буюу 59 гаралтаар буурсан байна. Эхний 6 сард гарсан халдварт өвчний тоо өмнөх 4 жилийн эхний 6 сард гарсан халдварт өвчний дунджаас 41 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Халдварт өвчний гаралт



Хүн амд зонхилон тохиолдох халдварт өвчнүүд 2013 оны эхний 6 сар, нийт өвчинд эзлэх хувиар



Хүн амд зонхилон тохиолдох халдварт өвчнийг хувиар авч үзвэл гепатит өвчин өмнөх оны мөн үед нийт халдварт өвчний 32.9 хувийг эзэлж байсан бол энэ оны 6 сарын байдлаар 18.3 пунктээр буурч, харин БЗХӨ 12.8 пунктээр өсч, салхинцэцэг 5.8 пунктээр буурсан байна.

10000 хүн тутмаас 38.9 нь халдварт өвчнөөр өвчилж байгаа бөгөөд Давст /107.2/, Зүүнговь /76.5/, Улаангом /61.0/, Түргэн /44.6/, сумдад аймгийн дунджаас 5.7 – 68.3 продецимилиэр дээгүүр, Завхан /35.3/, Тэс /33.2/, Ховд /27.3/, Наранбулаг /27.2/, Цагаанхайрхан /25.6/, Бөхмөрөн /23.8/, Сагил /23/, Хяргас /20.9/, Өлгий /18.9/, Тариалан /18.7/, Өмнөговь /13.9/, Малчин /12.3/, Баруунтуруун /12.1/ Өндөрхангай /9.5/ сумдад аймгийн дунджаас 3.6 – 29.4 продецимилиэр доогуур, Зүүнхангай суманд гараагүй байна.

Халдварт өвчнөөр өвчлөгсдийн 14.6 хувь нь гепатит, 39.6 хувь нь БЗХӨ, 12.2 хувь нь сүрьегээр, 6.3 хувь нь мөөгөнцөрөөр, 13.2 хувь нь гахайн хавдараар, 14.2 хувь нь бусад халдварт өвчнөөр өвчилжээ.





Өнгөрсөн оны мөн үеэс тэмбүү 26, гахайн хавдар 37, хүйтэн 8, цусан суулга 4 гаралтаар нэмэгдэж, мөөгөнцөр 2, трихомониаз 13, сүрьеэ 1, бруцеллёз 9, салхинцэцэг 25, гепатит 72, хамуу 11 гаралтаар тус тус буурч, мэнэн өвчин өнгөрсөн оны мөн үеийн түвшинд буюу гараагүй байна.





Амбулаториор 187.0 мянган хүнд үзлэг хийгдэж, 10.6 мянган хүн хэвтэн эмчлэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс амбулаториор үйлчлүүлсэн хүнээс 11.9 мянган хүнээр, хэвтэн эмчлүүлэгчид өнгөрсөн оны мөн үеэс 171 хүнээр тус тус өссөн байна.

Хувийн хэвшлийн 12 эмнэлэгээр энэ оны эхний 6 сард нийт 6099 хүн үзлэг, эмчилгээ оношлогоо хийлгэсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 1003 хүнээр их байна. Мөн хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын үйлчилгээний орлого 73.4 сая төгрөг байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 5.4 сая төгрөгөөр буюу 7.9 хувиар өссөн байна.

1.5 Соёл

Аймгийн хөгжимт драмын театр нийт 44.7 мянган хүнд 208 тоглолтоор үйлчилж ажилласан нь өнгөрсөн оны мөн үеэс тоглолтын тоо 11.1 хувиар буурч, үзэгчид нь 17 хувиар өссөн бол орлого 16.4 хувиар буурсан байна.

Хөгжимт драмын театрын тоглолтын тоо өмнөх 3 жилийн дунджаас 37.7 хувиар, үзэгчид 45.1 хувиар тус тус өссөн байна.



Орон нутгийг судлах музей 2.1 мянган хүнд үйлчилж 1454.4 мянган төгрөгийн орлоготой ажилласан нь өнгөрсөн оны мөн үеэс үзэгчид 12.5 буурсан бол орлого нь 28.2 хувиар өссөн байна. Орон нутгийг судлах музейн орлого өмнөх 3 жилийн дунджаас 60.1 хувиар, үзэгчдийн тоо 14.8 хувиар тус тус өссөн байна.



Төв номын сан 2.3 мянган байнгын уншигч, 14.8 мянган ирэгсдэд 19.5 мянган номоор үйлчилсэн байна. Өмнөх оны мөн үеэс уншигчдын тоо 15.0 хувиар нэмэгдэж, уншуулсан ном 8.5 хувиар буурсан байна..



1.6 ГЭМТ ХЭРЭГ

Оны эхний хагас жилд бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 148 болж өнгөрсөн оны мөн үеэс 11.4 хувиар буурч, өмнөх 4 жилийн дунджаас 42 гэмт хэргээр буюу 22.1 хувиар буурсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо



Гэмт хэргийн өнгөөр авч үзвэл өнгөрсөн оны мөн үеэс хүний амь эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 16.3, бусдын бие мах бодид гэмтэл учруулах хэрэг 15.2 хувь, хүүхэд гэр бүл нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг 2.5 дахин өсчээ.

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг өнгөрсөн оны мөн үеэс 34.5 хувиар, үүнээс нийт хулгайн гэмт хэрэг 30.6 хувиар, малын хулгайн хэрэг 46.9, бусад хулгайн хэрэг 83.3 хувиар тус тус буурсан байна.

Өмнөх оны эхний хагас жилд гарч байгаагүй хүнийг санаатай алах гэмт хэрэг, захиргааны журмын эсрэг , албан тушаалын , дээрмийн гэмт хэргүүд 1-3 тохиолдол гарч, нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 25.0 хувиар буурсан байна.

Оны эхний хагас жилд 131 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсаны 8.4 хувь буюу 11 нь эмэгтэйчүүд байна. Өнгөрсөн оны мөн үеэс гэмт хэрэгт холбогдсон хүмүүсийн тоо 10.3 хувиар буурсан байна. Гэмт хэрэгт 18 хүртэл насны 8 хүүхэд холбогдсон нь өнгөрсөн оны мөн үеэс 2.6 дахин өссөн байна.

Гэмт хэргийн улмаас иргэд байгууллагад 681.4 сая төгрөгийн хохирол учраад байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 2 дахин өссөн байна. Нийт иргэд байгууллагад учруулсан хохирлын 16.3 хувийг нөхөн төлүүлсэн байна.

Гэмт хэргийн 35.8 хувь нь согтуугаар, 10.8 хувь нь бүлэглэж үйлдэгдсэн бөгөөд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 39.5 хувь өсч, бүлэглэж үйлдэгдсэн гэмт хэрэг 62.8 хувиар буурсан байна.



Шүүхээр 48 гэмт хэрэгт 76 хүн ял шийтгүүлсэн нь таслуулсан гэмт хэргийн тоо өнгөрсөн оны мөн үеэс 23.8 , шийтгүүлсэн хүний тоо 21.6 хувиар буурсан байна. Шүүхээр таслуулсан

гэмт хэргийн тоо өмнөх 4 жилийн дунджаас 1.6 дахин, ял шийтгүүлсэн хүний тоо 1.7 дахин буурсан байна.





Ял шийтгүүлсэн хүмүүсийн 57.9 хувь нь 17-35 насны залуучууд, 94.7 хувь нь эрэгтэйчүүд байна. Улаангом суманд 0-16 насны 3 хүүхэд шүүхээр ял шийтгүүлсэн байна.

Шүүхээр таслуулсан гэмт хэрэгтний дийлэнх буюу 31.6 хувь нь эрүүгийн хуулийн тусгай ангийн бусдын эд хөрөнгө хулгайлах, 10.5 хувь нь эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх, 6.6 хувь нь хууль бусаар Монгол улсын хилийг нэвтрэх, 7.9 хувь нь тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчих, ойн тухай хууль зөрчих, бусдын бие мах бодод хөнгөн гэмтэл санаатай учруулах заалтаар шийтгэгдсэн байна.

II. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД :

2.1 Хэрэглээний үнийн индекс

Сар бүрийн 15-21 ний байдлаар хүн амын өргөн хэрэглээний 12 бүлэг, сагсны 213 нэрийн барааны үнийн өөрчлөлтийг судалж сарын инфляци тооцож байдаг. Энэ оны 6-р сарын 15-30 нд судлагдаж буй өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ тариф өнгөрсөн оны мөн үеэс 9.3, оны эхнээс 3.1, суурь оноос 27.5, өмнөх сараас 0.2 хувиар өсчээ.

Өмнөх сараасаа хүнсний бараа, согтууруулах бус ундааны барааны бүлгийн үнэ тариф 0.3, эм тариа эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 0.1 хувиар өсч, тээврийн бүлгийн үнэ 0.3, гэр ахуйн тавилга гэр ахйн барааны бүлгийн үнэ 0.4 хувиар буурч, бусад бүлгийн үнэ тогтвортой байлаа.

ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНЭ,
ТАРИФЫН ИНДЕКС 6-р сарын 21 ний байдлаар

	2013-06 2010-12	2013-06 2012-06	2013-06 2012-12	2013-06 2013-05
ЕРӨНХИЙ ИНДЕКС	127.5	109.3	103.1	100.2
01. ХҮНСНИЙ БАРАА, СОГТУУРУУЛАХ БУС УНДАА	133.2	109.3	104.8	100.3
02. СОГТУУРУУЛАХ УНДАА, ТАМХИ, МАНСУУРУУЛАХ БОДИС	165.8	161.1	105.0	105.0
03. ХУВЦАС, БӨС БАРАА, ГУТАЛ	135.7	111.1	103.4	100.0
04. ОРОН СУУЦ, УС,ЦАХИЛГААН, ХИЙН БОЛОН БУСАД ТҮЛШ	119.8	110.4	101.1	100.0
05. ГЭР АХУЙН ТАВИЛГА, ГЭР АХУЙН БАРАА	132.8	108.5	102.7	99.6
06. ЭМ ТАРИА, ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	128.2	108.5	107.0	100.1
07. ТЭЭВЭР	116.9	103.4	101.5	99.7
08. ХОЛБООНЫ ХЭРЭГСЭЛ, ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	96.6	96.5	99.6	100.0
09. АМРАЛТ,ЧӨЛӨӨТ ЦАГ,СОЁЛЫН БАРАА,ҮЙЛЧИЛГЭЭ	106.3	101.3	100.9	100.0
10. БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ	117.9	110.0	100.0	100.0
11. ЗОЧИД БУУДАЛ, НИЙТИЙН ХООЛ, ДОТ.БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	149.9	105.0	105.2	100.0
12. БУСАД БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	132.1	109.5	102.5	100.0



Өмнөх сараасаа 9 бүтээгдэхүүний үнэ 33-4000 төгрөгөөр өсч, 10 бүтээгдэхүүний үнэ 33-3000 төгрөгөөр буурсан байна.

Гол нэрийн барааны өсөлт, бууралтын хувь

	өмнөх сарааc	ӨОМҮГ-с
гурил дээд зэрэг	0.0	20.0
гурил, 1-р зэрэг	0.0	12.5
хонины мах	0.0	16.7
үхрийн мах	0.0	16.7
адууны мах	0.0	-10.0
ямааны мах	18.2	30.0
хиам	0.0	13.9
сүү	-13.4	-12.5
тараг	-29.4	0.0
ургамлын тос	0.0	4.4
алим	0.0	0.0
мандарин	0.0	16.3
төмс	0.0	-26.1
байцаа	25.0	33.3
лууван	100.0	33.3
манжин	76.5	33.3
Бензин,А-80, 1 литр	-1.6	1.2
Бензин,А-92, 1 литр	-1.4	1.1
Дизелийн түлш , 1 литр	-1.5	0.9

Өмнөх сараасаа ямааны мах 18.2, байцаа 25.0, манжин 76.5 хувиар, луувангийн үнэ 1 дахин өсч, сүү 13.4, тараг 29.4, А80 1.6, А92 1.4, дизелийн түлш 1.5 хувиар буурсан байна.

Өнгөрсөн оны мөн үеэс гурил 12.5-20.0, мах 16.7-30.0, хиам 13.9, ургамлын тос 4.4, мандарин 16.3, байцаа, лууван, манжин 33.3 хувиар өсч, сүү 12.5, төмс 26.1, адууны мах 10 хувиар буурсан байна.



Сүүлийн 5 жилийн 6 сарыг: - оны эхтэй харьцуулсан индексээс харахад 2012 оны 6 сард хамгийн өндөр буюу 6.2 хувийн өсөлттэй

- өмнөх сартай харьцуулсан индексээс харахад хамгийн өндөр өсөлт нь 2012.6 сард 1.1 хувь байна.

Сарын инфляцийн түвшин



2013 он гарсаар 1 дүгээр сард өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ тариф өмнөх сараасаа 1.6, 2-р сард 0.3 хувиар өсч, 3-р сард 0.9 хувиар буурч, 4-р сард 1.9 хувиар өсч 5 сард өмнөх сарын түвшинд, 6 сард 0.2 хувиар өссөн байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулснаар барааны бүлгүүдээр үнийн өөрчлөлтийг тооцож үзвэл :

Хүнсний бараа, үндаа ус 9.3 %	Хүнсний бараа, үндаа усны бүлгийн үнэ дүнгээрээ 9.3 хувь өссөн нь талх, гурил будааны бүлгийн үнэ 9.0 %, мах махан бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 14.8, жимс жимсгэний дэд бүлгийн үнэ 2.6, саахар,чихрийн бүлгийн үнэ 12.5,хүнсний бусад бүтээгдэхүүний бүлгийн үнэ 11.3, согтууруулах бус ундааны дэд бүлгийн үнэ 5.5 хувь өссөнтэй холбоотой байна.
Согтууруулах ундаа, тамхи 61.1 %	Согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 61.1 % өссөн нь согтууруулах ундааны дэд бүлгийн үнэ 42.2, тамхины дэд бүлгийн үнэ 86.8 хувь өссөнтэй холбоотой байна.

Хувцас гутал бөс бараа, гутал 11.1 %	Хувцас, гутал, бөс барааны бүлгийн үнэ дүнгээрээ 11.1 хувь өссөн нь хөвөн бөс барааны бүлгийн үнэ 11.9, үүнээс бүх төрлийн хувцасны дэд бүлгийн үнэ 8.2 % , жижиг эдлэл хэрэгслийн дэд бүлгийн үнэ 4.3, гутлын дэд бүлгийн үнэ 18.3 хувь өссөнтэй холбоотой байна.
Орон сууц , ус 11.0 %	Орон сууц, түлш цахилгааны бүлгийн үнэ дүнгээрээ 11.0 хувь өссөн нь орон сууцны засвар үйлчилгээний дэд бүлгийн үнэ 7.8, усан хангамж болон орон сууцны үйлчилгээний бүлгийн үнэ 7.2, цахилгаан болон бусад түлшний бүлгийн үнэ 16.7 хувь өссөнтэй холбоотой байна.
Гэр ахуйн бараа, тавилга 8.5 %	Гэр ахуйн бараа, тавилганы бүлгийн үнэ дүнгээрээ 8.5 хувь өссөн нь гэрийн тавилганы бүлгийн үнэ 7.4 , цахилгаан барааны бүлгийн үнэ 2.2 ,гэр ахуйн шилэн эдлэл, сав суулганы барааны бүлгийн үнэ 17.4, оёмол, нэхмэл, эдлэлийн үнэ 17.6, гэх ахуйн цэвэрлэгээний болон бусад жижиг барааны бүлгийн үнэ 11.4 хувь өссөнтэй холбоотой байна.
Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ 8.5 %	Эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 8.5 хувь өссөн нь эм тариа эмнэлгийн хэрэгслийн үнэ 9.8, амбулаторийн үйлчилгээний үнэ 2.4 хувиар өссөнтэй холбоотой байна.
Тээвэр 3.4 %	Тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 3.4 хувь өссөн нь хувийн тээврийн хэрэгслийн худалдан авалтын дэд бүлгийн үнэ 4.3, тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээний үнэ 2.4, тээврийн үйлчилгээний үнийн дэд бүлгийн үнэ 4.3 хувь өссөнтэй холбоотой байна.
Холбооны үйлчилгээ - 3.5 %	Холбооны үйлчилгээний үнэ тариф 3.5 хувь буурсан нь холбоо шуудангийн үйлчилгээний үнэ тариф 3.5 хувиар буурсантай холбоотой байна.
Амралт чөлөөт цаг соёлын үйлчилгээ 1.3 %	Амралт чөлөөт цаг соёлын үйлчилгээний бүлгийн үнэ 1.3 % өссөн нь дуу дүрс, гэрэл зураг, мэдээлэл боловсруулах тоног төхөөрөмжийн дэд бүлгийн үнэ 1.2, ном,сонин,бичгийн хэрэгслийн дэд бүлгийн үнэ 1.4 хувь өссөнтэй холбоотой байна.
Боловсролын үйлчилгээ 10.0 %	Боловсролын үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 10.0 % өссөн нь их дээд сургуулийн төлбөр 10.0 хувиар өссөнтэй холбоотой байна.
ЗБ нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ 5.0 %	Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ 5.0 % өссөн нь нийтийн хоолны үйлчилгээний дэд бүлгийн үнэ 6.1 хувь өссөнтэй холбоотой байна.
Бусад бараа үйлчилгээ 9.5 %	Бусад бараа үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 9.5 % өссөн нь хувь хүний эд зүйл хэрэглэлийн дэд бүлгийн үнэ 6.8, хувь хүнд хандсан үйлчилгээ 31.6 хувь өссөнтэй холбоотой байна.

Өргөн хэрэглээний 11 бараа, бүтээгдхүүний үнийг 7 хоног бүрийн 3 дахь өдөр цуглуулж өөрчлөлтийг судалж байна. 2013 оны 6-р сарын 30 ны байдлаар Улаангом хотын хүнсний зах, дэлгүүрт худалдаалагдаж байгаа хүнсний гол нэрийн барааны үнийг дүнгээр нь өмнөх 5 дугаар сарын дундаж үнэтэй харьцуулахад 3.2 хувь буурсан байна. Өмнөх сарын дундаж үнээс хонины мах 1.8, шингэн сүү 36.8 хувиар буурч, цагаан будаа 3.9 , ямааны мах 11.6, үхрийн мах 0.5 хувиар өссөн байна.

Махны дундаж үнэ:

6-р сард ямаа үхрийн махны дундаж үнэ хэвээр, хонины мах 66-166 төгрөгөөр буурсан байна.



6-р сард дунджаар 1 кг хонины мах 6842, үхрийн мах 7000, ямааны мах 6100, 1 л шингэн сүү 750 төгрөгийн үнэтэй байсан байна.





2.2 МӨНГӨ ЗЭЭЛ

Монгол банкны эх үүсвэрээр 24.8 тэрбум төгрөг зузаатгалаар авч, 189.1 тэрбум төгрөг гүйлгээнд гаргаснаас 198.2 тэрбум төгрөгийг буюу гаргасан мөнгөний 104.8 хувийг эргүүлэн татсан байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад зузаатгалаар авсан мөнгө 3.1 тэрбум төгрөгөөр буюу 14.5 хувиар, гүйлгээнээс татсан мөнгө 12.7 тэрбум төгрөг буюу 6.8 хувиар тус тус өссөн бол гүйлгээнд гаргасан мөнгө 20.2 тэрбум төгрөг буюу 9.7 хувиар буурсан байна.

Зээлийн өрийн үлдэгдэл 102.5 тэрбум төгрөгт хүрч, үүнээс хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 215.0 сая төгрөг болж ноднингийн мөн үеэс бүх зээлийн үлдэгдэл 31.6 тэрбум төгрөгөөр буюу 44.6 хувиар өсч, хугацаа хэтэрсэн зээл 48.5 сая төгрөгийн буюу 18.4 хувиар буурсан байна.

146.1 сая төгрөгийн найдваргүй зээл байгаа нь нийт зээлийн өрийн үлдэгдлийн 0.1 хувийг эзэлж байгаа бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс 63.9 сая төгрөгөөр буюу 30.4 хувиар буурсан байна.

Аж ахуйн нэгж, иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл өмнөх 3 жилийн дунджаас 54.3 тэрбум төгрөгөөр буюу 2 дахин өссөн байна.



Зээлийн өрийн үлдэгдлийн хэмжээгээр ХААН, Хас банк тэргүүлж байгаа бөгөөд тэдгээрийн зээлийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 80.6 хувьтай тэнцэж байна.

Төрийн банк нийт зээлийн 0.06, ХААН банк 0.21, Хас банкны 0.31, Хадгаламж банкны 0.12 хувийг хугацаа хэтэрсэн зээл тус тус эзэлж байна.

Иргэдийн хадгаламжийн үлдэгдэл 49.7 тэрбум төгрөг болж байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 18.6 хувиар буюу 7.8 тэрбум төгрөгөөр өсчээ. Сүүлийн 4 жилийн дунджаас иргэдийн хадгаламжийн үлдэгдэл 24.5 сая төгрөгөөр буюу 2 дахин өссөн байна.



Арилжааны банкууд иргэд, аж ахуй нэгжид нийт 40.8 мянган зээлдэгчид 76.1 тэрбум төгрөгийн зээлийг олгосон бөгөөд төрлөөр нь авч үзвэл лизингийн зээл 3.4 хувь, хадгаламж барьцаалсан зээл 10.7 хувь, малчны зээл 8.0 хувь, бизнесийн зээл 30.7 хувь, орон сууцны зээл 8.5 хувь, цалингийн зээл 22.3 хувь, тэтгэвэрийн зээл 8.6 хувийг тус тус эзэлж байна. Нийт олгосон зээлийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад зээлдэгчдийн тоо 30.2 хувиар, зээлийн хэмжээ 88.8 хувиар тус тус өссөн байна.



2.3 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО

Улсын төвлөрсөн төсвийн шилжүүлэг, дэмжлэгийг оруулан тооцсоноор энэ оны эхний хагас жилд аймгийн төсөвт 8,3 тэрбум төгрөг оруулахаас 8,8 тэрбум төгрөгийн орлого орж төлөвлөгөөний биелэлт 106.3 хувьтай, 0,5 тэрбум төгрөгөөр давж биелэгдлээ.

Улсын төвлөрсөн төсвийн шилжүүлэг, дэмжлэгийг оруулалгүйгээр аймаг өөрөө 4,4 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлэхээс 4,7 тэрбум төгрөгийн орлогыг бүрдүүлж төлөвлөгөөг 105.2 хувиар биелүүлж 5.2 хувиар буюу 229,3 сая төгрөгөөр давуулсан байна.

Үүнээс улсын төвлөрсөн төсөвт 1.6 тэрбум төгрөгийг татвар, орлогын хэлбэрээр төвлөрүүлэхээс 1,7 тэрбум төгрөгийг төвлөрүүлж төлөвлөгөөг 103.8 хувиар биелүүлж 3.8 хувиар буюу 62,0 сая төгрөгөөр давуулан биелүүллээ. Аймгийн төсөвт өөрийн орлогоор 2.8 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээс 3,0 тэрбум төгрөгийг төвлөрүүлж төлөвлөгөөг 105,9 хувиар биелүүллээ.

Өнгөрсөн оны мөн үе буюу 2012 оны эхний хагас жилтэй харьцуулахад аймгийн төвлөрүүлсэн нийт орлого 13,5 хувиар буюу 554,0 сая төгрөгөөр илүү, үүнээс улсын төвлөрсөн төсөвт төвлөрүүлсэн орлого 6,7 хувиар буюу 120,6 сая төгрөгөөр бага, аймгийн төсөвт төвлөрүүлсэн орлого 29,0 хувиар буюу 674,6 сая төгрөгөөр илүү байна.

2013 оны эхний хагас жилд улсын төвлөрсөн төсөвт төвлөрүүлэх орлогуудаас 1 нэр төрлийн төлөвлөгөө тасарч, 4 нэр төрлийн төлөвлөгөө 100-аас дээш хувиар биелэгдсэн байна. Үүнд онцгой албан татварын төлөвлөгөө 11,9 хувиар буюу 93,2 сая төгрөгөөр тасарч, ААНБ-ын орлогын албан татварын төлөвлөгөө 18,9 хувиар, нэмэгдсэн өртгийн албан татварын төлөвлөгөө 17,2 хувиар, ашигт малтмалын нөөцийн болон агаарын төлбөр 39,4 - 50,0 хувиар давж биелэгдлээ.

Мөн эхний хагас жилд аймгийн төсөвт өөрийн орлогоор төвлөрүүлэх орлогуудаас 7 нэрийн орлогын төлөвлөгөө тасарч, 8 нэрийн орлогын төлөвлөгөө давж биелэгдлээ.

Төлөвлөгөө тасарсан нэр төрлийг авч үзвэл цалингийн ашгийн орлогын төлөвлөгөө 3,8 хувиар, үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 8,4, ойгоос хэрэглээний мод, түлээ ашигласны төлбөр 20,6 хувиар, түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн төлөвлөгөө 25,0 хувиар, рашаан ус ашигласны төлбөр 35,4 хувиар, хог хаягдлын үйлчилгээний хураамжийн төлөвлөгөө 77,5, хүү торгуулийн орлогын төлөвлөгөө 6,5 хувиар тус тус тасарсан байна.

Харин хувираа аж ахуйн эрхлэгч иргэний орлогын төлөвлөгөө 13,2 хувиар, авто өөрөө явагч хэрэгслэлийн татварын төлөвлөгөө 7,2, үл хөдлөх хөрөнгө, бууны татварын орлогын төлөвлөгөө 76,9 хувиар, улсын тэмдэгтийн хураамжийн төлөвлөгөө 51,2, газрын төлбөр 37,0, хөрөнгө борлуулсны орлого 30,1, агнуурын нөөц ашигласны төлбөр 15,8 дахин, нэр заагдаагүй орлогын төлөвлөгөө 52,1 хувиар тус тус давж биелэгдсэн байна.

Өнгөрсөн 2012 оны эхний хагас жилийнхээс хувираа аж ахуй эрхлэгч иргэний орлого 43,7 хувиар, үйл ажиллагааны орлого 15,1 хувиар бага, бусад орлогууд 20,9 хувиас 208,4 дахин өндөр байна.

Аймгийн төсвийн орлогын 66,1 хувийг тусламжийн орлогоор, 25,2 хувийг орлогын албан татвараар, 2,1 хувийг татварын бус орлогоор, 2,0 хувийг тусгай зориулалтын орлогоор, 3,6 хувийг бусад татвар хураамжаар, 1,0 хувийг өмчийн татвараар бүрдүүлсэн байна.



Ноднингийн мөн үетэй харьцуулахад тусламжийн орлогын эзлэх хувь 8,5 пунктээр өсч, орлогын албан татварын эзлэх хувь 6,3 пунктээр буурсан байна.

Сүүлийн 4 жилийн дунджаас тусламжийн орлогын эзлэх хувийн жин 2,5 пунктээр өсч, орлогын албан татварын эзлэх хувийн жин 1,6 пунктээр буурсан байна.

Аймгийн өөрөө бүрдүүлэх орлогын хэмжээ жил бүр тасралтгүй өсч ирсэн бөгөөд 2013 оны эхний 6 сарын гүйцэтгэлийг сүүлийн 4 жилийн дундажтай харьцуулахад 38,3 хувиар өссөн байна.



Оны эхний 6 сард аймгийн төсвийн нийт зарлагад өөрөө бүрдүүлсэн орлогын эзлэх хувь 19,2 хувь болж сүүлийн 4 жилийн дунджаас 0,1 пунктээр буурсан байна.

Суурь он буюу 2005 оны эхний 6 сартай харьцуулахад аймаг өөрөө бүрдүүлсэн орлого 2013 оны эхний 6 сард 6,9 дахин өндөр, энэ хугацаанд төсвийн зарлага 5,9 дахин өссөн байна.

2009 I-VI / 2005 I-VI	2010 I-VI / 2005 I-VI	2011 I-VI / 2005 I-VI	2012 I- VI / 2005 I- VI	2013 I- VI / 2005 I- VI

2.4 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА

Орон нутгийн төсвийн болон улсын төсвийн байгууллагуудын дүнгээр 24,4 тэрбум төгрөгийн зардал гаргасан нь өнгөрсөн оны мөн үеэс 7,9 хувиар бага байна. Нийт зарлагын 56,4 хувийг цалин хөлсөнд, 6,1 хувийг эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлд, 17,6 хувийг бусад зардалд, 5,7 хувийг урсгал шилжүүлэгт, 1,8 хувийг хөрөнгө оруулалтанд, 11,9 хувийг халамжийн санд, 0,4 хувийг замын сангаас санхүүжүүлэх үйл ажиллагаанд зориулан зарцууллаа.



Өнгөрсөн оны мөн үеэс цалин хөлсний зардлын эзлэх хувь 0,1 пунктээр өсч, хөрөнгө оруулалтын зардлын эзлэх хувь 0,4 пунктээр буурсан байна.

2.5 ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГУУДЫН ӨГЛӨГ, АВЛАГА

Улсын төсвийн болон орон нутгийн төсвийн байгууллагуудын дүнгээр 2013 оны эхний хагас жилд 1140,5 сая төгрөгийн өртэй, 73,1 сая төгрөгийн авлагатай гарч, өмнөх сараасаа өглөг 3 дахин буюу 730,2 сая төгрөгөөр өсч, авлага 1,2 сая төгрөгөөр буюу 1,6 хувиар буурлаа. Өнгөрсөн оны мөн үеэс өглөг 29,7 хувиар буюу 158,0 сая төгрөгөөр, авлага 1,23,7 хувиар буюу 37,8 сая төгрөгөөр тус тус буурсан байна.

6 – р сард 822,6 сая төгрөгийн өр шинээр үүсч, 92,3 сая төгрөгийн өр төлөгдөж сарын эцэст 655,3 сая төгрөгийн цалингийн, 78,3 сая төгрөгийн НДШ-ийн, 3,3 сая төгрөгийн ЭМДШ - ийн, 3,4 сая төгрөгийн гэрэл цахилгааны, 212,6 сая төгрөгийн түлш, халаалтын, 1,0 сая төгрөгийн цэвэр, бохир усны, 56,1 сая төгрөгийн тээвэр, шатахууны, 28,3 сая төгрөгийн албан томилолтын, 0,9 сая төгрөгийн шуудан холбооны , 8,8 сая төгрөгийн хоолны, 17,4 сая төгрөгийн эмийн, 3,7 сая төгрөгийн урсгал засварын, 35,5 сая төгрөгийн бусад зардлын өртэй байна.



Төсөвт байгууллагын өглөг сүүлийн 4 жилийн дунджаас 725.9 сая төгрөгөөр буюу 3 дахин өссөн байна.

Энэ оны 6 дугаар сарын эцэст байгаа өрийн хэмжээ оны эхний сарынхаас 14,8 дахин өсч 1104,5 сая төгрөгт хүрсэн байна.

2.6 ГАДААД ХУДАЛДАА

Нийт импорт 11235.7 мян.ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 12214.43 мян.ам доллараар буюу 52.1 хувиар буурсан байна. 115 тн гурил, 5.8 мянган тн нефть бүтээгдэхүүн, 39674.0 мян,квт,цаг цахилгаан, 694 ш мебель тавилга, 283.8 тн овъёс, 3 ш мод хөрөөдөх машин, 158.4 мянган л чацарганы жүүс, 2 ш тусгай зориулалтын автомашин, жимс жимсгэнэ 16.7 тн, хатуу чихэр 6.9 тн, хиам 0.4 тн, жүүс 13.8 мян.л тус тус импортоор оруулсан байна.



Өнгөрсөн оны мөн үеэс импортоор оруулсан мебель тавилга 21.3 хувиар, хүнсний ногоо 25, цахилгаан 7.0 хувиар тус тус өссөн бол овъёс 14.7 хувиар, авто бензин 62.5 хувиар, гурил 96.6 хувиар, дизель түлш 65.3 хувиар, чихэр 68.9 хувиар тус тус буурсан байна.

Нийт экспорт 4.5 мянган ам. долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 116.5 мян. ам. доллараар буюу 96.3 хувиар буурсан байна. Энэ оны эхний 6 сард 4 ш монгол гэр, 70 м2 эсгий гаргасан байна.

III. ЭДИЙН ЗАСГИЙН САЛБАРЫН ҮЗҮҮЛЭЛТ

3.1 АЖ ҮЙЛДВЭР

Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 1.5 тэрбум төгрөг болж өнгөрсөн оны мөн үеийнхээс 30.8 хувиар буюу 674.0 сая төгрөгөөр буурч, бууралт өнгөрсөн сараас 0.8 пунктээр саарсан байна.

Аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл оны үнээр 2.7 тэрбум төгрөг болж, өмнөх оныхоос 956.3 сая төгрөгөөр буюу 25.8 хувиар буурсан байна. Нийт үйлдвэрлэлтийн бууралтанд архины үйлдвэрлэлт, дулаан түгээлт, усан хангамж, сироп, шүүс, жимсний чанамлын үйлдвэрлэлт, гурил гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, нүүрс олборлолтын бууралт түлхүү нөлөөлсөн байна.

Нийт үйлдвэрлэлтийн 43.7 эрчим хүч усан хангамж 46.4 хувийг боловсруулах үйлдвэрлэл, 9.9 хувийг уул уурхайн салбар эзэлж байна.



Дэд салбараар тооцвол нийт үйлдвэрлэлтийн 29.4 хувийг хүнс ундааны үйлдвэрлэлт, 41.6 хувийг эрчим хүч, дулаан түгээлт, 9.9 хувийг уул уурхайн олборлолт, 3.5 хувийг өлөн гэдэс боловсруулалт, 2.2 хувийг усан хангамж, 3.6 хувийг арьс шир, гутал үйлдвэрлэл, 0.4 хувийг мод модон бүтээгдэхүүний үйлдвэрлэл, 0.2 хувийг хувцас үйлдвэрлэл, 1.1 хувийг бусад боловсруулах үйлдвэрлэл эзэлж байна.

Аж үйлдвэрийн салбарын бүтэц



Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад аж үйлдвэрийн салбарт эзлэх эрчим хүч түгээлт, усан хангамжийн салбар 12.4 пунктээр өсч, уул уурхай олборлолтын салбар 0.7, боловсруулах үйлдвэр 11.7 пунктээр буурсан байна.

Салбарын бүтэц

	2011 I-VI	2012 I-VI	2013 I-IVI
Цахилгаан дулаан түгээлт, усан хангамж	20.1	31.3	43.7
Уул уурхай олборлолт	11.7	10.6	9.9
Боловсруулах Үйлдвэрлэл	68.2	58.1	46.4
ДҮН	100.0	100.0	100.0

Өнгөрсөн оны мөн үеэс /зэрэгцүүлэх үнээр тооцсоноор / мах махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл 6.0, сүү сүүн бүтээгдэхүүн 75.0, бусад боловсруулах үйлдвэрлэл 19.3 хувиар, үүний дотор арьс шир гутлын үйлдвэрлэл 2.2д, өлөн боловсруулалт 2.6 хувиар өсч, дулаан түгээлт 7.9, усан хангамж 22.6, нүүрс олборлолт 29.4, хүнс ундааны үйлдвэрлэл 67.3 хувиар үүний дотор архи ундааны үйлдвэрлэл 83.1, хүнсний бусад бүтээгдэхүүний / сироп, варень/ үйлдвэрлэл 55,1 хувиар буурсан байна.

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлт оны үнээр 2.7 тэрбум төгрөг, борлуулсан бүтээгдэхүүн 3.0 тэрбум төгрөг болж борлуулалт өнгөрсөн оны мөн үеэс 30.2 хувиар буурсан байна.

2005 оны зэрэгцүүлэх үнээр тооцсоноор суурь он болох 2005 оноос боловсруулах үйлдвэрлэл 10.0, эрчим хүч усан хангамж түгээлт 85.4 хувиар, уул уурхай олборлох салбар 54.2 хувиар өссөн байна.



Аж үйлдвэрийн салбарын зарим нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлтийг 2005 оны мөн үетэй харьцуулбал талх 21.0д, нүүрс 68.0д нарийн боов 2.5д, дулаан түгээлт 91.4, өлөн боловсруулалт 61.3 хувиар өсч, түгээсэн цэвэр ус 1.4, архи ундаа үйлдвэрлэл 72.4 хувиар буурсан байна.



гол нэрийн бүтээгдэхүүний өсөлт бууралт 2005 I-VI=100%/





2005 оны мөн үеэс импортын цахилгаан 2.1, цахилгааны хэрэглээ 2.1 хувиар өссөн байна.



Аж үйлдвэрийн чиглэлийн 71 аж ахуйн нэгж 62 нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн байна. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний гол нэр төрлийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 15 нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэнд өсөлт гарч, 18 нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл буурч, өнгөрсөн оны мөн үед үйлдвэрлэгдэж байгаагүй 25 нэрийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, үйлдвэрлэж байсан 2 нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгдээгүй байна.

Өнгөрсөн оны мөн үеэс зарим гол нэрийн бүтээгдэхүүнээс морин хуур 10.3д, гэрийн модон тавилга 10.0д, пальто 5.5д, вакум цонх 3.7д, эмэгтэй хослол 3.3д, гутал 2.9д, модон ор 2.7д, талх 63.2, гэрийн хөшиг 50.0, тараг 38.7, тоосго 32.3, булигар 30.0, дээл тэрлэг 25.0, блок 8.3 , өлөн гэдэс 2.5, хувиар өслөө.

Харин нарийн боов 2.9, чацарганы шүүс 8.0, дулаан түгээлт 8.4, шевро үйлдвэрлэлт 12.5, дээврийн хавтан 17.7, гоймон 21.1, цэвэр ус түгээлт 22.5, нүүрс олборлолт 29.4, чацарганы тос 34.2, чацарганы сироп 34.9, замын алаг хавтан 40.0, хивэг 40.3, ажлын хувцас үйлдвэрлэл 47.1, хэрчсэн гурил 54.8, гэрийн бүрээс 58.3, булигар 70.0, хөх шир 71.4, архи 87.7 хувиар буурч, хиам, варень, үйлдвэрлэл өнгөрсөн оны түвшинд байна.

Аж үйлдвэрийн салбарын ажиллагсдын тоо 601 болж өнгөрсөн оны мөн үеэс 4.9 хувиар өсч 1 ажиллагчийн хөдөлмөрийн бүтээмж 28.6 хувиар буурлаа.

зарим нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт

/биет хэмжээгээр/

		2009 I-VI	2010 I-VI	2011 I-VI	2012 I-VI	2013 I-VI
дулаан	мянгкал	38.8	46.8	37.3	65.4	59.9
нүүрс	тн	15.5	24.7	29.3	23.8	16.8
архи	мян л	271.4	299.1	306.9	203.5	25.1
ундаа	мян л	91.7	67.2	0.5	0.0	1.5
нарийн боов	тн	84.4	98.7	93.4	119.8	116.3
өлөн	мян гог	73.4	67.0	68.4	36.2	37.1
гурил	тн	0	0	0	0.0	84.0
чацарганы тос	кг	77.3	101.9	56.5	164.5	108.2
чацарганы ш/с	мян л	9.7	3	2.1	2.5	2.3
чацарганы сироп	мян л	2	7.7	8.3	14.6	9.5
талх	тн	43.2	62.9	58.5	48.9	79.8
хэрчсэн гурил	тн	13.3	16.6	25	21.0	9.5
хиам	тн	1.9	2.8	3.1	2.4	2.4
цэвэр ус т/гээлт	мян л	250.1	245.2	255.5	309.0	239.4
булигар	мян квм	1.1	0.6	0.6	1.0	1.3
шевро	мян квм	0.7	0.5	0.4	0.8	0.7
хөх шир	тн	0.4	0.5	0.3	0.7	0.2
гутал	хос	490	819	157	809	2345
тоосго	мян ш	100.0	170.0	810.0	491.3	650.0
вакум цонх	кв м	24.5	40.2	0	40.0	147
замын хавтан	мян ш	5	24.9	15.0	30.0	18


Зарим нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт
/биет хэмжээгээр/
350.0
300.0
250.0
200.0
150.0
100.0
50.0
0.0
271.4
299.1
306.9
203.5
25.1
77.3
101.9
93.4
119.8
108.2
84.4
98.7
56.5
164.5
116.3
2009 I-VI
2010 I-VI
2011 I-VI
2012 I-VI
2013 I-VI
архи /мян л/
нарийн боов /тн/
чацарганы тос /кг/


Зарим нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт
/биет хэмжээгээр/
100
80
60
40
20
0
91.7
73.4
67.2
67
68.4
43.2
62.9
58.5
48.9
79.8
36.2
37.1
15.5
24.7
29.3
23.8
16.8
0.0
1.5
2009 I-VI
2010 I-VI
2011 I-VI
2012 I-VI
2013 I-VI
талх /тн/
нүүрс /мян тн/
ундаа /мян л/
өлөн гэдэс /мян гогцоо/


Зарим нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт
/биет хэмжээгээр/
16
14
12
10
8
6
4
2
0
9.7
7.7
8.3
14.6
9.5
2
3
2.1
2.5
2.3
0
0
0
0
0.0
2009 I-VI
2010 I-VI
2011 I-VI
2012 I-VI
2013 I-VI
чацарганы шүүс /мян л/
сироп /мян л/
алт олборлолт /кг/





3.2 Барилга

Барилгын гүйцэтгэгч 33 аж ахуйн нэгжүүд 6.3 тэрбум төгрөгийн БУИЗ-ын ажил гүйцэтгэсэн нь өнгөрсөн оны мөн үеэс /инфляциар засварласанаар/ 32.8 хувиар бага байна. Нийт гүйцэтгэсэн ажлын 85.3 хувийг шинэ барилга, 14.7 хувийг их засварын ажил эзэлж байна. Барилгын салбарын ажиллагсдын тоо 869 байгаа нь өнгөрсөн оноос 17.9 хувиар өссөн байна.

Барилга угсралт их засварын ажил

		БУ, ИЗ-ын ажил /мян төг/		хувь	ажиллагсдын тоо	
		2012 I-VI	2013 I-VI	2013 I-VI / 2012 I-VI	2012	2013
	БУИЗ-ын ажил	8529000.3	6266522.1	73.5	737	869
инфляциар засварласнаар /9.3/		9322197.3	6266522.1	67.2		
үүнээс	Барилга объектын ажил	4100763.3	4662266.4	113.7		
	Инженерын барилга байгууламж	5221434.0	1604255.7	30.7		



Нийт барилга угсралтын ажлын 74.4 хувийг барига объектын ажил, 25.6 хувийг инженерийн барилга байгууламж эзэлж байгаа нь өнгөрсөн оноос барилга объектын ажил 13.7 хувиар өсч, инженерийн барига байгууламжийн ажил 69.3 хувиар буурсан байна.



Увс барилга ХХК энэ оны 1-р сард 400.0 сая төгрөгийн үндсэн фонд бүхий бизнес инкубатор төвийн барилгыг ашиглалтад хүлээлгэн өгсөн байна.

Нийт барилга угсралт их засварын ажлын 24.9 хувь буюу 1.6 тэрбум төгрөгийн ажлыг Улаанбаатар хот, Хөвсгөл аймгийн аж ахуйн нэгжүүд, 75.0 хувь буюу 4.7 тэрбум төгрөгийн ажлыг аймгийн гүйцэтгэгч ААН-үүд гүйцэтгэсэн байна.

3.3 ХӨДӨӨ АЖ АХУЙ

3.3.1 Төллөлт, төл бойжилт

Оны эхний эхийн 87.2 хувь буюу 782.8 мянган эх мал төллөж, гарсан төлийн 97.8 хувь буюу 767.3 мянган төл бойжиж байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад байжилтын хувь 1.0 пунктээр их, төлийн хорогдол 3.6 мянган толгойгоор бага байна.

Бөхмөрөн, Малчин, Наранбулаг, Өлгий, Өмнөговь, Өндөрхангай, Тариалан, Ховд, Түргэн, Хяргас, Улаангом сумдын мал төллөлт аймгийн дунджаас 1.8 – 11.0 пунктээр өндөр, бусад сумдад дунджаас 1.3 – 19.2 пунктээр бага байна.

Нийт 17.0 мянган төл хорогдсоны 44.2 хувийг хурга, 49.5 хувийг ишигний хорогдол эзэлж байна.

Давст /99.3/, Завхан /99.8/, Зүүнговь /99.5/, Малчин /98.1/, Наранбулаг /99.9/, Өлгий /99.0/, Өмнөговь /99.8/, Сагил /98.9/, Цагаанхайрхан /99.0/, Улаангом /99.2/ сумдын төл бойжилтын хувь 99.0 – 99.9 байгаа нь аймгийн дунджаас 1.2 – 2.1 пунктээр их, бусад сумдын төл бойжилтын хувь аймгийн дунджаас 1.0 – 5.5 пунктээр бага байна.





3.3.2 Том малын зүй бусын хорогдол

Оны эхний малын 1.1 хувь буюу 22.6 мянган толгой мал хорогдсон нь өнгөрсөн оныхоос 17.8 хувь буюу 4.9 мянган толгойгоор буурсан байна.





Нийт хорогдлын 40.8 хувийг хонь, 48.6 хувийг ямаа, 6.3 хувийг үхэр, 4.1 хувийг адуу, 0.3 хувийг тэмээний хорогдол тус тус эзэлж байна.

Баруунтуруун сумын оны эхний малын 8.6 хувь, Өндөрхангай сумын 6.4 хувь, Давст сумын 1.3 хувь, Түргэн сумын 1.2 хувь нь хорогдож аймгийн дунджаас 0.1 – 7.5 пунктээр илүү, бусад сумдын оны эхний малын хорогдол 0.3 – 0.9 пунктээр бага байна.

3.3.3 Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний дундаж үнэ

Малын үнэ: 2013 оны 06 - р сарын 28-ны байдлаар тус аймагт буурны үнэ 1200.0, атны үнэ 1080.0 мянга, ингэний үнэ 850,0, унаганаас бусад насны адууны үнэ 512,5 – 1250,0 мянга, бухны үнэ 850.0, бусад бүх насны үхрийн үнэ 160.0 – 1190.0 мянга, хурга ба бүх насны хонины үнэ 63.3 – 175.6 мянга, ишигний үнэ 20.0, бусад бүх насны ямааны үнэ 55.0 – 125.0 мянган төгрөгний дундаж үнэтэй байна.

Өмнөх сартай харьцуулахад буурны үнэ 50.0, атны үнэ 20.0, ингэний үнэ 16.7 мянга, үнээний үнэ 21.3, хуцны үнэ 5.0, ухна ишигний үнэ 1.6, өсвөр насны үхрийн үнэ 25.0 мянган төгрөгөөр тус тус буурч, бусад малын үнэ 0.8 – 273.3 мянган төгрөгөөр тус тус өсчээ.

Арилжаалагдаж байгаа бүх малын үнэ өнгөрсөн оны 6 сарын 28-ны байдлаас 13.5 – 114.0 хувиар өссөн байна. Үүний дотор буурны үнэ 71.4, атны үнэ 29.6, ингэний үнэ 30.8, морины үнэ 55.2, гүүний үнэ 114.0, өсвөр насны адууны үнэ 43.0, шар үхрийн үнэ 53.5, үнээний үнэ 35.5, өсвөр насны үхрийн үнэ 20.0, эр хонины үнэ 13.5, эм хонины үнэ 29.4, эр ба эм төлөгний үнэ 23.0, эр ямааны үнэ 28.2, эм ямааны үнэ 42.8, эр ба эм борлоны үнэ 33.3 хувиар тус тус өссөн байна.

ХАА - н зарим бүтээгдэхүүн:

Гол нэрийн бүтээгдэхүүн болох хонины арьс 10000, ямааны арьс 4000, тэмээний мах 5000, ноолуур 60000 төгрөгийн дундаж үнэтэй байна.

Өмнөх оны мөн үеэс ноолуур 38.7 хувиар, ямааны арьс 33.3, хонины арьс 25.0 хувиар өсчээ.

Газар тариалан болон бусад бүтээгдэхүүн:

Сонгино кг нь 2000, түлээний мод м. куб нь 33.3 мянган төгрөгийн дундаж үнэтэй байна.

Өмнөх сартай харьцуулахад түлээний мод 8.7 хувиар өссөн байна. Зөгийн балны үнэ өмнөх сарын түвшинд, богийн сүүний үнэ өмнөх сараас 25 хувиар буурсан байна.







3.3.4 Үр тариа, төмс, хүнсний ногоо тариалалт

10332.5 га-д үр тариа, үүнээс 10085.0 га-д улаан буудай, 235.8 га-д төмс, 229.9 га-д хүнсний ногоо, 463 га-д тэжээлийн ургамал нийт 11.3 мянган га-д тариалалт хийлээ. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад үр тариа 1900.3 га, хүнсний ногоо 22.1 га -гаар өсч, төмс 37.1 га, тэжээлийн ургамал 108.3 га-гаар тус тус буурчээ.

Баруунтуруун сум 9337 га, Тариалан сум 668.3 га-д үр тариа тариалсан нь аймгийн нийт тариалсан үр тарианы 96.8 хувийг эзэлж байна. Тариалан, Баруунтуруун, Улаангом сумдад 368.0 га-д төмс, хүнсний ногоо тариалсан нь хүнсний ногоо тариалалтын 79.0 хувийг эзэлж байна.

Хаврын тариалалтанд 1205.6 тн үрийн буудай, 462.8 тн төмсний үр, 1.6 тн хүнсний ногооны үр хэрэглэсэн байна.





4.1 Тээвэр холбоо

Зорчигч тээврийн үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж байгууллага, иргэд 24.5 мянган зорчигч тээвэрлэж 18212.0 мян.хүн.км-ийн зорчигч эргэлт хийснийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад зорчигчдын тоо 5.2 хувиар өссөн бол зорчигч эргэлт нь 2 дахин өссөн байна.
Ачаа тээврийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэд 22.1 мян.тн ачаа тээвэрлэж 15649.7 мян.тн.км-ийн ачаа эргэлт хийснийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад тээсэн ачаа нь 1.3 хувиар буурсан бол ачаа эргэлт 2 дахин өссөн байна.



Холбооны үйл ажиллагаа эрхэлж, мэдээнд хамрагддаг аж ахуйн нэгж газрууд 175.4 сая төгрөгийн орлоготой ажилласны 30.9 хувь нь хүн амаас орсон ба өнгөрсөн оны мөн үеэс нийт орлого нь 2.3 хувиар буюу 4,0 сая төгрөгөөр өссөн байна.

Холбооны газраар үйлчлүүлсэн цахилгаан мэдээ 0.1 мян.ш, бичиг, захидал, боодол 11.0 мян.ш байгаа ба өнгөрсөн оны мөн үеийнхээс бичиг, захидал, боодол 7.3 хувиар өссөн бол цахилгаан мэдээ 45.0 хувиар байна.

Аймгийн бүх сумдад үүрэн телефоны операторууд үйл ажиллагааны явуулж байгаа ба тэдний хэрэглэгчдийн тоо өнгөрсөн оны мөн үеэс 16.1 хувиар өссөн байна.

Үүрэн телефон хэрэглэгчдийн тоо, операторуудаар



5.1 ЦАГ УУРЫН БАЙДАЛ

2013 оны 6-р сард агаарын дундаж температур Тэс, Улаангом, Баруунтуруун, Завхан, Давст, Зүүнговь, Сагил, Наранбулаг, Түргэн,Ховд, Хяргас сумдад +15-аас дээш, хөрсний дундаж температур Завхан, Давст, Наранбулаг,Сагил,Түргэн сумдад +25-с дээш хэм байлаа.

10 м/сек-ээс их салхитай өдөр Улаангомд 13, Наранбулаг 10, завханд 18, Баруунтуруунд 20, Өндөрхангайд 23, Малчинд 11, Зүүнхангай, Цагаанхайрханд байхгүй, бусад сумдад 3-8 хоног байв. Баруунтуруун, Улаангом, Өмнөговьд 15, Өндөрхангай, Малчинд 10, Завхан, Ховд, Хяргаст 11 хоног тунадастай байж Малчинд 39.6, Баруунтуруунд 46.6, Өмнөговьд 39.9,Цагаанхайрханд 37.2,Өмнөговьд 39.9 мм хур тунадас орсон байна.

Ургамлын өндөр Малчинд 13, Өмнөговьд 12,Тэсд10 бусад сумдад 2-8 см байлаа.

Агаарын чанарын мэдээгээр хүлцэх агууламжаас давсан үзүүлэлт одоогоор гараагүй байна. Өнгөрсөн оны мөн үеэс азотын давхар исэл 0,006 мг/м^3 , агаарт байх хүхэрлэг хийн хэмжээ 0.001 мг/м^3 аар буурсан байна.

6.1 АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСЛЫН МЭДЭЭ

Аймгийн ОБХ-ийн мэдээлснээр 2013 оны эхний 6 сард аймгийн хэмжээнд 2.5 - 5.5 магнитудын газар хөдлөлт 7, үерийн 3, объектын гал түймэр 44, ой хээрийн түймэр 5, мал амьтны гоц халдварт өвчний 13, үйлдвэрлэлийн осол /тээврийн хэрэгслийн/ 1, хүчтэй салхи шуурганы тохиолдол 10, гол мөрний осол 1 гарсан байна.

Хүчтэй салхи шуурганы улмаас иргэдэд 34.6 сая төгрөг, зам тээврийн ослоос 350.0 мянган төгрөгийн , объектын гал түймрийн улмаас иргэд байгууллагад 193.6 сая төгрөгийн хохирол учирч 766.2 сая төгрөгийн эд хөрөнгийг авран хамгаалжээ. Эхний хагас жилд ой хээрийн түймрийн 5 тохиолдлоор 373 га хадлан бэлчээрийн талбай шатаж байгаль экологид 8398.7 сая төгрөгийн хохирол учирсан нь өнгөрсөн оны мөн үеэстүймрийн тоо 60 хувиар ,учирсан хохирол 118.8 дахин буурсан байна.

Объектын гал түймрийн тоо өнгөрсөн оны мөн үеэс 5.5 дахин, учирсан хохирол 3.2 дахин, аварсан хөрөнгө нь 1.4 дахин нэмэгджээ. Гол мөрний ослоор Цагаанхайрхан суманд 2 хүн нас барсан байна. Тариалан сумын Мянган багийн нутагт айлын хотонд үүл буудах зориулалттай пуужингийн хонгио унаж үүнээс болж ямар нэгэн хохирол учраагүй байна.

АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, 2013 ОНЫ ЭХНИЙ 6 САРД

		2009 I-VI	2010 I-VI	2011 I-VI	2012 I-VI	2013 I-VI
Төрсөн хүүхдийн тоо		1258	1018	864	1011	1007
0- 5 насны хүүхдийн эндэгдэл, тоо		42	60	30	22	25
1000 амьд төрөлтөнд ноогдох		33.4	58.9	31.1	21.8	24.8
0-1 насны хүүхдийн эндэгдэл		37	47	26	17	20
1000 амьд төрөлтөнд ноогдох		28.6	46.2	27.0	17.0	19.9
Нас барсан хүний тоо		269	282	222	237	208
Халдварт өвчний гаралт		600	534	472	347	288
10000 хүнд ноогдох халдварт өвчин		75.0	69.0	63.0	46.6	38.7
Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо		205	205	184	167	148
Хэрэглээний үнийн индекс, оны эхнээс, хувь		95.1	102.0	99.3	106.2	3.1
Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо, сарын эцэст, хүн		2264	1861	1161	782	1069
Банкны зээлийн үлдэгдэл, сая төг		24188.2	27248.6	46660.8	70935.7	102542.6
Үүнээс: хугацаа хэтэрсэн		202.7	1590.4	285.1	263.5	215.0
Аймгийн төсвийн орлого, оны үнээр, сая төг		2182.9	3201.8	4037.1	4117.3	4671.3
Төсвийн зарлага, оны үнээр, сая төг		13195.8	13805.6	18566.5	26445.4	24368.1
Төсвийн өглөг, сая төг		65.6	537.3	412.8	498.7	1104.5
Аж үйлдвэрийн бүтээгдхүүн үйлдвэрлэл, оны үнээр, сая төгрөг		2662.6	3388.8	3515.6	3701.6	2745.3
Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний харьцуулсан хувь		103.1	122.8	93.8	108.6	69.2
2005 оны зэрэгцүүлэх үнээр /сая төг/		1748.9	2147.7	2015.2	2187.9	1513.9
Үүнээс	Уул уурхай олборлох үйлдвэр	106.8	170.2	201.9	164.0	115.8
	Боловсруулах үйлдвэр	1073.5	1299.8	1264.8	1086.6	541.5
	Эрчим хүч, усан хангамж	568.6	677.7	548.8	937.3	856.6
Хорогдсон том мал мян.тол		258.3	616.2	25.1	27.5	22.6
Төллөсөн эх, мян.тол		838.0	667.4	699.1	651.3	782.8
Бойжсон төл, мян.тол		605	349.9	685.3	631.5	767.3
Тариалсан талбай, га		3509.9	5208.9	7532.9	9860.2	11251.2
